

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ АНХДУГААР ЧУУЛГАН

2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-12
<hr/>	
<i>1.Байнгын хорооны даргыг сонгох тухай</i>	4-9
<i>2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох эсэх асуудлаар шийдвэр гаргах тухай асуудал</i>	9-13

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн  
анхдугаар чуулганы Ёс зүй, дэгийн байнгын хорооны  
2024 оны 7 дугаар сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 14 гишүүнээс 13 гишүүн ирж, 92.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 00 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

**Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны асуудал хариуцсан референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарыг Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны даргад нэр дэвшигч Б.Баярбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, Д.Бум-Очир, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Д.Рэгдэл: Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын Баярмагнайн Баярбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	3
Бүгд:	14

92.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

***Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох эсэх асуудлаар шийдвэр гаргах тухай асуудал***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны асуудал хариуцсан референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Г.Очирбат, П.Наранбаяр нар үг хэлэв.

**Д.Рэгдэл:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 3  
Бүгд: 14  
92.8 хувийн саналаар дэмжигдлээ.

“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

*Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.*

*Хуралдаан 35 минут үргэлжилж, 14 гишүүнээс 14 гишүүн ирж, 100 хувийн ирцтэйгээр 13 цаг 35 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.РЭГДЭЛ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,  
Баасан гараг Төрийн ордон “Үндсэн  
хууль” танхим 13 цаг 00 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Д.Рэгдэл:** Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Ингээд байнгын хорооны ирц бүрдсэн тул Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Ингээд ирцийг та бүхэнд танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Баярмагнай Баярбаатар ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах ирээгүй байна, Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилигийн Лодойсамбуу ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэг ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Галбадрах ирсэн байна, орж ирлээ. Рэгдэл ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Доржзовдын Энхтуяа ирсэн байна.

Ингээд ирц танилцуулчихлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хоёр асуудалтай юм байна.

Нэгдүгээр асуудал, Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал,

Хоёрдугаар асуудал, Чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох тухай асуудал. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Хэлэлцэх асуудлаар санал алга. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Эхний асуудал Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэнэ ээ.

Дэгийн тухай хуулиар Байнгын хорооны даргад Байнгын хорооны гишүүдийн дотроос олонхын саналаар нэр дэвшүүлнэ.

Ингээд УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Лхагвын Мөнхбаатар Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар танилцуулна аа.

Мөнхбаатар даргын микрофоныг өгөөрэй.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг эрье. 2024 оны ээлжит сонгуулиар байгуулагдсан УИХ бүтцийнхээ байгууллагуудын удирдлагыг сонгох үйл ажиллагаа явагдаж байна.

Өнөөдөр бүх Байнгын хороодын дарга нар сонгогдож томилогдоно. Ёс зүй, дэгийн байнгын хороонд МАН-ын бүлгээс Баярмагнай овогтой Баярбаатарыг даргад нэр дэвшүүлж байна аа. Баярбаатарын товч намтрыг та бүхэнд уншиж танилцуулъя аа.

Баярмагнайн Баярбаатар 1981 оны 4 сарын 8-нд төрсөн. Эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг. 1988-аас 1998 онд Нийслэлийн 48 дугаар сургуулийг төгссөн 98-аас 2003 онд Шихихутаг Хууль зүйн дээд сургууль, 2020-2021 онд

Шихихутаг Хууль зүйн дээд сургуульд магистрын зэрэг хамгаалсан, 2021 оноос МУИС-ийн Хууль зүйн сургуульд докторантураар суралцаж байна. Эрх зүйч мэргэжилтэй. 2003-аас 2004 онд Улсын Их Хурлын Тамгын газар, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргын туслах, 2004-2006 онд Улсын Их Хурлын дэд даргын шадар туслах, 2006-2008 онд Улсын Их Хурлын даргын шадар туслах, 2008-2011 онд УИХ дахь МАН-ын бүлэгт ахлах референт, 2011-2012 онд МАН-ын Удирдах зөвлөлийн Хэрэг эрхлэх газарт 2012 онд МАН-ын Удирдах зөвлөлийн Хэрэг эрхлэх газарт Нийгмийн бодлогын байнгын бодлогын байнгын хорооны дарга, 2012-2016 онд МАН-ын Удирдах зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын намын байгуулалтын хэлтэст Улс төрийн ахлах ажилтан, 2016-2020 онд МАН-ын Удирдах зөвлөлийн Ажлын албаны намын зохион байгуулалтын газрын дарга, 2020 оноос МАН-ын Хяналтын ерөнхий хорооны даргаар ажиллаж байсан.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатарыг байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна. Эрхэм гишүүд та бүгдийг дэмжиж өгөхийг хүсье.

**Д.Рэгдэл:** Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар танилцуулга хийсэн Мөнхбаатар даргад баярлалаа.

Одоо манай Байнгын хорооны гишүүдээс Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар өөр саналтай гишүүн байна уу? Өөр саналтай хүн байхгүй байгаа юм байна. Нэр дэвшигч Баярмагнайн Баярбаатараас асуух асуулттай гишүүд байвал асуултаа тавина.

Одоогоор 2 гишүүн байгаа юм байна Улсын Их Хурлын гишүүн гишүүдийг нь сайн таньж амжаагүй учраас. Ганбатын Очирбат гишүүнд микрофон өгөөрэй.

Баярлалаа.

**Г.Очирбат:** Байнгын хорооны гишүүддээ бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Ёс зүйн байнгын хороонд яг бодлогоор би өөрөө саналаа өгч орж ирсэн. орж ирэхдээ 2, 3 асуудал дээр нэлээн ажиллая гэж бодож орж ирж байгаа. Тэгээд Баярбаатар даргаас асуух гэж байгаа юм. Бид нар дөнгөж сая 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийг хийж дуусгалаа. Энд бол яг ТАЗ-тэй болон төрийн албан хаагчдын нэг талдаа ёс зүй, нөгөө талдаа эрхийг нь бид нар даргаар хэрвээ ажиллах үедээ яаж хамгаалах вэ? Сонгуулийн үеэр юу болж байсан юм гэхээр эрүүл мэндийн салбар болон боловсролын салбарынхан ингээд босоо тогтолцоотой салбарынхан бүгд даргаасаа айдаг, даргынхаа үгээр ажилладаг, тушаал өгөхөөр тэрийг нь биелүүлдэг. Хамгийн наад талын жишээ гэхэд өөрөө хувь хүнийхээ хувьд Ардчилсан намаас нэр дэвшиж байгаа хүнийг дэвшиж байгаа гээд өөрийнх нь оруулсан постын доор, танд баяр хүргэе ээ гээд бичихэд дүүрэг нийслэл болон боловсролын газар болон эрүүл мэндийн газраас нь дарамт үзүүлж чи сөрөг хүчний эсрэг намаас явж байгаа хүний доор коммент бичлээ, пост дээр нь лайк дарлаа гэдэг байдлаар энэ төрийн албан хаагч нарт их дарамт ирдэг. Тэгээд энэн дээр та ямархуу байр суурь илэрхийлж ажиллах вэ гэж 1 дүгээрт асуух гэсэн юм.

Хоёрдугаарт гэх юм бол та бүхэн бид нар энд чинь Ёс зүй, дэгийн байнгын хороо гэхээр Их Хурлын гишүүдтэй, ялангуяа Их Хурлын гишүүнтэй холбоотой өргөдөл гомдлууд дээр их ажиллана. Тэгэхээр энэн дээр та ямар байр суурийг барьж ажиллах вэ? Өнгөрсөн 2020-2024 оны жишээг харахаар Ёс зүй, дэгийн байнгын хороо Их Хурлын гишүүдийн ирцийг зарлаад өнгөрдөг. Тийм ээ тэр нь тэдэн минут хоцорсон байна энэ нь ингэж ирээгүй байна гэдэг нэг ийм л чиг үүрэгтэй юм шиг

ажиллаад байдаг. Яг үндсэндээ Ёс зүй, дэгийн байнгын хороо энэ чинь Дэгийн тухай хуулиараа нэлээн том эрх үүрэгтэй ийм Байнгын хороо байгаад байдаг. Тэгээд энэ дээр бас яг өөрийнхөө байр суурийг хэрхэн яаж ажиллах вэ гэдэг байр сууриа илэрхийлээч гэж асуух гэсэн юм. Ийм 2 асуулт байна.

Баярлалаа.

**Д.Рэгдэл:** Баярбаатар гишүүн.

**Б.Баярбаатар:** Байнгын хорооны гишүүд Улсын Их Хурлын гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ. Магадгүй манай Байнгын хороо бусад Байнгын хороодоос хамгийн цөөн гишүүнтэй Байнгын хороо болж бүрдэж байх шиг байна. Үндсэндээ бол бусад эдийн засаг, боловсрол, төсөв гэсэн Байнгын хороо руу ер нь хошуурцаагаад яг манай энэ асуудал эрхэлж байгаа Байнгын хороо руу нэг их орох сонирхол байдаггүй юм байна. Тэгээд өнөөдөр энэ Байнгын хороондоо энэ санал болгоод орж ирж байгаа Улсын Их Хурлын гишүүддээ юуны өмнө талархал илэрхийлье.

Өнөөдөр энэ бүх юмны суурь өөрөө энэ ёс зүй болчихоод байгаа гэдгийг л нийгэм өөрөө ойлгохгүй байгаа юм. Бүх шатандаа анхан, дунд, дээд гээд ерөөсөө. Тэгэхээр энэ ёс зүй дээрээ бид нар ер нь яаж код гаргаж ажиллах юм бэ? Энэ хувь хүний ёс суртахууныг яаж тэр байгууллагын ёс зүйд нийцүүлэх юм бэ гэдэг асуудал өөрөө их чухал болж байгаа. Яг энэ дээр холбогдуулаад Очирбат гишүүний асуултад хариулах нь зөв байх гэж бодож байгаа.

Байгууллага болгон өөрийн гэсэн онцлогтой. Дээр нь энэ хуульд захирагддаг байх ёстой. Хууль нь өөрөө ёс зүй, ёс суртахуундаа нийцсэн байх ёстой. Өнөөдөр энэ УИХ, хууль тогтоох байгууллага цорын ганц байгууллага.

Тэгэхээрээ бид нар энэ Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдоод явж

байгаа. Энэ 4 жилийн хугацаандаа яаж бид нар энэ хууль засагладаг байх ёстой юм бэ яаж хууль мөрдөгддөг байх ёстой юм бэ гэдэг дээр гол анхаарлаа хандуулж тэгээд төрийн албан хаагчдын энэ ёс зүйн алдаа дутагдал зарим зүйлээс нь урьдчилан сэргийлэх байдлаар нэлээдгүй ажлуудыг хийх ёстой гэж үзэж байгаа. ТАЗ-ийн дэргэдэх Ёс зүйн хороотой. Энэ бусад төрийн албаны байгууллагуудын мөрдөгдөж байгаа ёс зүйн дүрэм журмуудтай нь танилцаж, анализ судалгааг нарийн түвшинд хийж байгаа. Энэ хэрэгжилт нь хэрхэн хангагдаж явдаг юм.

Дээр нь энэ нийгэмд нэг буруу ойлголт байгаад байгаа л даа. Ер нь нэг хяналтын байгууллага ёс зүйн байгууллага гэхээр нэг тийм хариуцлага тооцдог нэг л нэг тийм буруу ний нуугүй хэлэхэд нэг тийм муу нэртэй л хүн нэг их халдаад байдаггүй наадах чинь ер нь их тийм амаргүй шүү дээ гэдэг байдлаар хандаад байдаг. Би өмнө нь МАН-ын хяналтын байгууллагыг 4 жил удирдаад явахад яг энэ том бүтцийн байгууллага тийм амар биш байдаг юм. Амар биш байдаг. Тэгээд энэ нь өнөөдөр парламентын түвшиндээ ороод ингээд явж байна.

Өргөдөл гомдлуудтай хэрхэн ажиллах вэ гэж. Улсын Их Хурлын гишүүдийн энэ ёс зүйн асуудал бас өөрөө 1 дүгээрт тавигдах ёстой асуудал. Өнөөдөр энэ парламентын нэр хүндийн асуудал. Энэ төр иргэн 2-ын хоорондын үл итгэлцлийг хэрхэн ойртуулах вэ гэдэг асуудлын хамгийн суурь нь дахиад л энэ ёс зүйн асуудал болж байгаа юм. Хувь хүний ёс зүйн ард талд. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд бүрдсэн парламент тэр чигээрээ тийм.

**Д.Рэгдэл:** Хугацаа болчихлоо. Сунгагддаггүй юм байна. Тэгэхээр энэ асуулт хариулттай холбогдуулаад Дэгийн тухай хуулиас заалтыг нь уншаад өгчихье. Гишүүний асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа нэг минутаас илүүгүй байх бөгөөд

хариулт тайлбар хангалтгүй гэж үзвэл тухайн гишүүн нэг минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт хариулт авах юм байна. Хариулт өгөх хугацаа 3 минут юм байна аа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа асуултаа асууна аа. Энхтуяа гишүүний микрофоныг өгөөрэй.

**Д.Энхтуяа:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Ёс зүйн байнгын хороонд цөөхөн гишүүнтэй тэгээд ерөнхийдөө ордоггүй юм байна гэдэг энэ үгийг сонсоод би гайхаж байна. Энэ Улсын Их Хурлын нэр хүнд төрийн эрх барих дээд байгууллагын нэр хүнд бол энэ Байнгын хорооноос маш шалтгаална. Бид нарыг ингээд сонгууль хийгээд явж байхад ард түмэн маань энэ Их Хурлын гишүүнийг ёс зүйн асуудал гаргасан Их Хурлын гишүүнийг эргүүлэн татдаг байх ёстой гэдэг энэ санал санаачилгыг маш их гаргадаг. Бид нар ч гэсэн хэрвээ Их Хуралд ороод ажиллах юм бол ёс зүйтэй ажиллана.

Дээрээс нь ёс зүйн алдаа гаргасан Их Хурлын гишүүнийг эргүүлэн татдаг ийм хуультай байх ёстой гэсэн ийм санал санаачилгыг яриад л ингээд явж байдаг тэ. Тийм учраас энэ байнгын хороон дотроос би бол энэ ийм цөөхөн хүн сонгогдсон гэж мэдээгүй. Энд хамгийн түрүүнд саналаа өгч орж ирсэн. Энэ Байнгын хороодууд дотроос энэ бол хамгийн жин дарахуйц ийм хороо байх ёстой гэж би бодож байна.

Ер нь бол Улсын Их Хурлын нэр хүнд Улсын Их Хурлын гишүүдийн нэр хүнд бол ард түмний дунд бол маш муу байгааг бид нар бүгдээрээ мэдэж байгаа тэ? Ёс зүйн асуудлаар бол байнга л яригдаж байгаа. Жинхэнэ ёс зүйтэй хүмүүс чинь ард түмэн, ёс зүйгүй хүмүүс энэ ард нь суугаад байдаг юм шиг л ийм л хандлагатай болсон байгаа.

Тийм учраас надад асуулт алга. Ерөнхийдөө санаанууд маш давхацсан учраас шинээр томилогдох гэж байгаа дарга маань энэ Ёс зүйн байнгын хорооныхоо хурлыг амжилттай зохион байгуулж хамгийн жин дарах нэр хүндтэй тэгээд энэ Улсын Их Хурлын гишүүн гэдэг энэ эрхэм нэр хүндтэй ажлаа дурлаж хийж ажилдаа үнэнч шударга ажиллах байх гэж ингэж бодож байна.

Тэгээд танд амжилт хүсье.

**Д.Рэгдэл:** Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа танд баярлалаа.

Ингээд гишүүд асуултаа асуугаад хариултаа аваад дууслаа.

Одоо үг хэлэх гишүүн байвал саналаа, нэрээ өгөөрэй.

Уучлаарай Бум-Очир гишүүн үг хэлэх юм байна. Бум-Очир гишүүний микрофон ирчихсэн байна даа.

**Д.Бум-Очир:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ миний ойлгож байгаагаар бол маш хариуцлагатай Байнгын хороо. Сая Байнгын хорооны олон гишүүд хэлж байна. Би давтахгүйгээр ярихыг хичээе.

Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүйн асуудал манай Байнгын хороотой холбоотой болно. Их Хурлын гишүүд маань өөрсдөө өндөр ёс зүйтэй байх шаардлагатай. Олон түмний нүдэн дээр байгаа. Олон түмэндээ үлгэр дуурайлал болж байгаа ийм улсууд. Их Хурлын гишүүд дотроо энэ Байнгын хороонд орсон бид хэд бол тэднээсээ илүү өндөр ёс зүйтэй байх ийм хариуцлага хүлээж байгаа гэж би ойлгож байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол магадгүй энэ ёс зүйн тухай асуудал хаанаас хэнээс эхлэх вэ? Хэн манлайлах вэ гэвэл бид хэд манлайлах шаардлагатай болно оо. Тэгэхээр энийгээ бид нар бүгдээрээ ойлгож ямар хариуцлага үүрч байгаагаа



мэдээд энд сууж байгаа гэж бодож байна аа. Яагаад гэхээр Ёс зүйн байнгын хорооны нэг гишүүн ёс зүйн асуудалд ороход л, нэг үхрийн эвэр доргиход мянган үхрийн эвэр доргино гэгчээр бид нар бусад хүнд юу гэдэг юм үг хэлэх боломжгүй болно шүү дээ. Та нар өөрсдөө Ёс зүйн байнгын хороонд сууж байж ийм ёс зүйгүй байж байж надад ёс зүй заах гэлээ гэдэг. Тэгэхээр бусдад шаардлага тавих боломжгүй болох байх аа. Тэгэхээр бид нар миний ойлгож байгаагаар яг энэ асуудлаар хамгийн өндөр хариуцлагатай, байнга алхах гишгэх, гадаа гудамжинд явах, мэдэхгүй янз бүрийн асуудалд оролцох гээд жижгээс өгсүүлээд том хүртэл тийм ээ авлига хээл хахууль юу байдаг юм бүхий л тал дээр анхаарах шаардлагатай. Тэгж байж бид нар үлгэр дуурайлал үзүүлнэ. Эхлээд эхний ээлжид парламент дотроо үлгэр дуурайлал үзүүлнэ.

Үүний дараа парламентын гишүүд маань бүх нийтээрээ олон нийтдээ үлгэр дуурайлал үзүүлнэ. Тэрний дараа харин ёстой түрүүн сая Баярбаатар дарга энэ хэлж байна. Энэ бүхний ард нөгөө төрд итгэх итгэл байгаа байхгүй юу. Би нэг Монгол ёс заншил энэ тэр юм жаахан судалдаг санаатай хүн байгаа. Монголчууд төрийнхөө сүлдэнд залбирдаг ийм ард түмэн. Миний эмээ намайг бага байхад өглөө орой болгон төрийн минь сүлд өршөө гээд л одоо бол төрийг тэгж дээдэлдэг энэ ёс харьцангуй юу гэдэг юм өөрчлөгдөх гэх юм уу төрөө хараад загнах нь их болсон. Тэгээд би энэ юунаас болсон гэж үздэг вэ гэхээр магадгүй өнгөрсөн хугацаанд 30 жилийн хугацаанд ч юм уу тийм ээ төр засагт удирдах албан тушаал хийж байсан Улсын Их Хурлын гишүүд болоод бусад улсуудын ёс зүйгээс болсон болов уу. Төрийг төлөөлж ажиллаж байсан олон мянган хүмүүс байгаа. Тэр хүмүүсийн хариуцлагагүй байдлаас болж ингээж төрийн нэр хүнд унасан байх аа. Үүний үүднээс төрд итгэх итгэл унасан болов уу гэж бодож байна аа.

Тэгэхээр энэ төр гэд гэдэг зүйл чинь Монгол Улсыг Монголын ард түмнийг Монгол үндэстнийг нэгэн тусгаар тогтносон улс болгож байж байгаагийн хамгийн том бэлгэдэл шүү дээ тэ? Тэгэхээр ирээдүйд бид энэ төрөө үнэлдэг, үнэ цэнтэй байлгахад бид хэд болоод манай парламентын гишүүд цаашилаад төрийн албан хаагчид хамгийн чухал үүрэг гүйцэтгэх ёстой гэж бодож байна аа.

Тэгээд энэ тал дээр бүгдээрээ цаашидаа.

**Д.Рэгдэл:** Бум-Очир гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал үг хэлнэ ээ.

**Х.Баасанжаргал:** Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе.

Хоёр санал хэлэх гэсэн юм.

Нэгдүгээрт бид нар ажлаа нөгөө хэмжиж эхлэх хэрэгтэй болов уу гэж бодож байна. Саяхан МУИС-ийн социологийн хүрээлэнгээс гарсан иргэдийн төрд итгэх итгэлийн судалгаа байсан. Тэрний хамгийн т эхний 2-т бол Ерөнхийлөгчийн институт, батлан хамгаалах хоёрт Монголчууд хамгийн их итгэдэг гэж гарсан. Хамгийн итгэдэггүй нь гэсэн чинь парламент, улс төрийн намууд гэж гарсан. Тэгэхээр бид нар магадгүй энэ хэмжээсээр ч юм уу эсвэл манай Байнгын хороо дотроо ярилцаж байгаа ч юм уу тэ. Ажлын албаныхантайгаа ярьж байгаад бид нарыг яг энэ ажлыг эхлэхэд ямар цэг дээрээс эхэлсэн юм явцын дунд ямар байгаа юм бэ гэдгээ үнэлэх хэрэгтэй болов уу гэж. Нэг ийм санал байна.

Хоёрдугаарт манай хийх нэг чухал ажил бол энэ Улсын Их Хурлын гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн асуудал дээр урьдчилж дүгнэлт гаргадаг

байх. Тэгээд Их Хурал дээр болоод парламент дээр ямар нэгэн шийдвэр гаргах гэж байгаа бол тухайн гишүүн хэрвээ ашиг сонирхлын зөрчилтэй гэдэг дүгнэлт нь урьсан гарсан байх юм бол түүнээс тэр шийдвэр гаргалтад оролцдоггүй байх дээр манай хороо бол аягүй чухал үүрэгтэй оролцох болов уу гэсэн ийм 2 санал байна.

**Д.Рэгдэл:** Баасанжаргал гишүүнд баярлалаа.

Ингээд гишүүд үг хэлж дууссан байна.

Санал хураалт явуулна аа.

Санал хураалтын томъёолол. Улсын Их Хурлын гишүүн Баярмагнай овогтой Баярбаатарыг Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн томъёолоор санал хураана.

Ингээд 57.1 хувийн саналаар санал хураалт хангалттай юм биш үү? Энэ чинь заавал өндөр байх албагүй.

Хариулъя.

Тэгвэл ингэж болж байна уу? 3 гишүүний санал ороогүй байна шүү дээ, дэмжсэн. Тэрнийг нь нэмээд тооцчих уу? Тэгэхээр болно гэж сая болно гэж. Ингээд протоколд бол хэдэн хувиар байх нь вэ? 14 гишүүнээс 11 гишүүн дэмжиж саналаа өглөө. Хувийг нь бодоод гаргачихна биз.

Ингээд Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцээд дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд манай гишүүдээс хэн танилцуулах вэ? Гараа өргөчих хүн байна уу?

Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа Улсын Их Хуралд танилцуулна аа.

Ингээд 2 дахь асуудалд 1 дүгээр асуудлаа хэлэлцээд дууслаа.

13.23 цагт

Хоёрдугаар асуудалдаа оръё.

Чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох тухай асуудал.

Хоёр дахь асуудалдаа оръё. Дэгийг шинэчлэн тогтоох тухай асуудал.

Тайлбар уншиж танилцуулах юм байна. Улсын Их Хурлын тухай хуулийн 28.1 Ёс зүй, дэгийн байнгын хороо хуралдааны дэгийг шинэчлэн батлах эсэх асуудлыг анхдугаар чуулганы хугацаанд хэлэлцэж санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулна аа.

Хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох асуудлаар Ерөнхий нарийн бичгийн дарга саналаа гаргаж Ёс зүй, дэгийн байнгын хороонд хүргүүлж болох юм байна.

Тэгэхээр энэ хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох асуудалтай холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү?

Энүүгээр орж ирэхгүй юу. Асуух асуулттай гишүүд нэрээ өгчих.

Ингээд асуулт асуух гишүүдийг Ганбатын Очирбат гишүүнээр тасалж байна. Бид Улсын Их Хурлын гишүүн Баярмагнай Баярбаатар асуулт асууна аа.

**Б.Баярбаатар:** Өдрийн мэнд хүргэе.

Асуулт юу яах вэ зүгээр энэ асуултад хэн хариулах юм гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаарт ТББХ-ны гишүүн байгаа.

ТББХ-н дээр сая ЕНБД-ыг шинээр томиллоо Тамгын газрын. Их Хурлын дарга өөрөө оролцоод энэ дэгтэй холбоотой асуудлыг ярилцсан. Энэ дээр ямар асуудал яригдсан бэ гэхээр ямар ч байсан бид нар энэ өнгөрсөн 76 хэдийн энэ 126 гишүүний дэгийг баталсан. Өнөөдөр бол энэ шинэ дэгийг бол нэлээн олон улсын судалгаанд суурилж баталсан дэг байгаа учраас энэ намрын ээлжит чуулганыг дуустал энэ дэгээрээ явъя гэсэн ийм зарчмыг ТББХ-н дээр гаргасан. Тийм энэ өнөөдөр мөрдөгдөж байгаа дэгээр. Тэгэхээр энэ дэгээрээ явъя гэдэг зарчмыг гаргаад энийг яг манай Байнгын хороо руу холбогдох удирдлагууд нь энэ тайлбарыг ирүүлсэн байж байгаа.

Тэгэхээр бид өнөөдрийн хурлаар энэ дэгд өөрчлөлт оруулах шаардлагагүй ээ. Явцын дунд л хуулиараа Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газрын ЕНБД-аас санал гаргаж энэ дэгд бол өөрчлөлт оруулах шаардлагатай. Тэгэхдээ бид нар нэг ийм чуулганы намрын чуулганаар энэ дэгээрээ яваад үзье гэсэн ийм саналтайгаар Төрийн байгуулалт дээр явсан гэдэг тайлбарыг би хүргүүлчихье. Тийм, энэ шинэ дэгээрээ тийм.

**Д.Рэгдэл:** Баярбаатар гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат асуулт асууна аа.

Би бас гайхаад л байгаа. Энэ асуултад хэн хариулах юм бол гээд л. Тэгэхдээ юу ч гэсэн асуултаа асууя. Микрофоныг нь өгөөрэй. Очирбат гишүүний микрофоныг өгөөрэй.

**Г.Очирбат:** Харин яг юу Баярбаатар дарга хариулчихлаа л даа.

Нэгдүгээрт хэн нь хариулах гэж байсан гэж асуух гэж байсан.

Хоёрдугаарт энэ Дэгийн журмын төсөл нь хэрэгтэй. Бид нар чинь энэ

Байнгын хорооны гишүүд энэ чинь төсөлтэйгөө танилцмаар байна шүү дээ. Шууд орж ирээд юмыг автоматаар ингээд шийдээд явах гэж байгаа юм шиг нөхцөл байдал үүсэхээр нь асуулт асууя, үг хэлье гэсэн юм. Тэгээд ямар ч байсан Баярбаатар дарга түр хуучин дэгээрээ явъя. Явахаар шийдсэн юм байна тийм ээ? Тэгж ойлголоо, баярлалаа.

**Д.Рэгдэл:** Баярлалаа. Ямар ч байсан бид нар асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрээ өгч болно. Нэрээ юугаараа системээрээ дамжуулаад нэрээ өгчхөөрэй. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр үг хэлье гэж байна. Наранбаярыг микрофонд нь урья.

Наранбаяр гишүүнд микрофон өгөөрэй.

**П.Наранбаяр:** Баярлалаа.

Хэдийгээр энэ хорооны гишүүн биш ч гэсэн надад үг хэлэх боломж олгосон Баярбаатар дарга болон гишүүдэд талархал илэрхийлье. Хурал даргалагчид маань талархал илэрхийлье ээ.

Тэгэхээрээ энэ Венецийн Комиссын өгсөн зөвлөгөө нээлттэй нийгэм форумаас өмнөх Дэгийн төсөлд өгсөн зөвлөгөөнийг би нарийн харж уншсан. Тэгээд ер нь бол Улсын Их Хурлын анхдугаар чуулган дээр энэ Ёс зүй, дэгийн хороо маш чухал үүрэг гүйцэтгэдэг ийм хороо. Ялангуяа Их Хурлын тухай хуулийн 16.3.10.1, 3.10 дээр энэ хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох асуудлаар шийдвэр гаргаж оруулж энийг танилцуулах санал, дүгнэлтээ өгөх нь энэ дэгийн тухай хуулийнхаа заалтаар энэ хороо юм байна лээ. Тэгэхээр энэ удаад намрын чуулганыг дуустал ямар ч байсан энэ асуудлыг хэлэлцэхгүй ээ. Ямар ч байсан энэ дэгээрээ яваад үзье гэсэн байгаа. Гэхдээ яах вэ зүгээр явах хүмүүс эр хүний ачааг татдаггүй бас нэг юм бий. Тэгэхээр энэ хуралд өөрөө өөрийнхөө дэгийг өөрчлөх алтан боломж байсныг эдэлж чадаагүйд бас жоохон харамсаж байна. Яагаад

гэхээр тэр зөвлөмжүүдийг түрүүнд хэлсэн зөвлөмжүүдийг харж байхад цөөнхийн дуу хоолойг сонсох тал дээр энэ дэг чинь өөрөө асуудалтай байгаа шүү.

Их Хурлын даргын дэргэд байгуулсан зөвлөл гэдэг зүйл чинь хэтэрхий их эрх мэдэлтэй асуудлуудыг яаралтай горимоор оруулах эрх нь Их Хурлын даргадаа хадгалаатай ийм юмнаас болж хүний эрхийг зөрчсөн олон хуулиуд орж ирсэн шүү. Хот байгуулалт төлөвлөлттэй холбоотой асуудлууд ч гэсэн энүүгээр орж ирж байсан.

Тэгэхээр зэрэг энэ асуудлуудыг уг нь нэг мөр цэгцлэх шаардлага байсан гэж харж байгаа. Энэ цөөнхийн дуу хоолойг сонсох тал дээр бас өөрчлөлтүүдийг оруулах тэр Их Хурлын дарга дахь зөвлөлийг өөрийнх нь бие даасан бүтэц болгон хувиргах ийм асуудлууд байсан шүү. Энийг эрхэм гишүүд та бүхэн анхааралдаа авна уу гэж хүсэж байна.

Тэгээд эцэст нь боо ерөөсөө энэ нэгэнт энэ эрхээ эдлэхгүй гэж байгаа учраас та бүхэн маань энэ дэгийн хуулийн 36.1.1 дээр байгаа энэ заалтаараа шууд Улсын Их Хурлын гишүүд дэгээ өөрчлөх санаачилга гаргах гэсэн ийм байдалтайгаар ишидчихэж байгаа юм байна. Гэхдээ энийг миний энэ хэлсэн үгийг энэ протоколдоо оруулаад юутай ч гэсэн яваад үзье гэсэн та бүхний саналыг мэдээж хүндэтгэн сонсоно. Гэхдээ одоо бүлэг байгуулах тоо жишээлбэл 10 хүн байгаа.

Тэгэхэд тэр Венецийн комиссоос өгөөд байгаа нь бол 6 хувиас дээш бүлэг байгуулж тэгээд цөөнхөө сонсдог ийм системтэй байх нь зүйтэй гэсэн ийм зөвлөмжүүд байсан шүү. Та бүхэн энийг мэргэн оюундаа толилоорой гэж хүсэж байна. Миний зүгээс бол протоколд ингээд тэмдэглүүлээд гаднын ийм гишүүн учраас энэ үгээ ингээд та бүхэн бодолцож үзээрэй гэж хэлээд тэгээд намрын чуулганы дараа ажил хэрэгчээр хэдүүлээ ярилцъя гэсэн ийм саналтай байна.

Баярлалаа.

**Д.Рэгдэл:** Наранбаяр гишүүнд баярлалаа.

Гишүүд асуулт асууж, үгээ хэлээд дууссан байна.

Санал хураалтыг явуулна аа.

Санал хураалтын томъёололыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Санал хураалт.

Санал хураалтын дүн гарсан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэсэн саналыг нийт гишүүдийн 14 гишүүний 10 буюу 71.4 хувь нь зөвшөөрсөн байна аа.

11-ээс 11. Үгүй ээ энэ гарч байгаа тоог чинь л хэлэхгүй би чинь санаагаараа тоо хэлээд байж болохгүй. Энийгээ жаахан янзалмаар юм байна. Энэ 14-өөс 11 гэж протоколд оруулъя. Тэгээд хувь нь өшөө нэмэгдээд явах юм байна аа. Баярлалаа.

Ингээд манай Байнгын хорооноос энэ дэгтэй холбоотой Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцах юм байна.

Монгол Улсын Их Хурлын тогтоол 2024 оны 7 дугаар сарын ... өдөр Улаанбаатар хот.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.10 дахь заалт Монгол Улсын

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын хуралдааны дэг гэж хүлээн зөвшөөрсөнд тооцсугай.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 36.1.1-д заасны дагуу шийдвэрлэсүгэй.

3. Энэ тогтоолыг 2024 оны 7 дугаар сарын ... өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм Их Хурлын энэ тогтоолын төсөл байна аа.

Ингээд манай Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүн хэн байна?

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна.

Ингээд хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

13.35 цагт

Дууны бичлэгээс буулгасан:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ  
П.МЯДАГМАА